Хурлын тов: 2024 оны 4 сарын 24-ний өдрийн 10:00 цагаас
Хурал болох байр: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Пиэрл Тауэр барилга, В корпус, 9 давхар 1 тоотод болно.

## "ХАЙ БИ ОЙЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

| | | |
|---|---|---|
| 1 | Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг) | 10:00-10:10 |
| 2 | Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг) | 5 минут |
| 3 | Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах | 15 минут |
| 4 | Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах | 50 минут |
| 5 | Хурлын завсарлага | 10 минут |
| 6 | Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах | 5 минут |
| 7 | Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах | 10 минут |
| 8 | Хурлыг хаах (хурлын дарга) | 5 минут |

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл хүргэх

# "ХАЙ БИ ОЙЛ" ХК – ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 15 өдөр Дугаар 04 Улаанбаатар

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам" болон "Хай Би Ойл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. "Хай Би Ойл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Лхагва гаригт 10:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Пиэрл Тауэр барилга, В корпус, 9 давхар 1 тоотод зарлан хуралдуулсугай.
2. "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
    a. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
    b. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
    c. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл хүргэх
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дугаар сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт № 1-ийн дагуу баталж, нийтэд мэдээллэх өдрийг ТУЗ-ын шийдвэр гарсанаас хойш 5 дахь өдөр буюу 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын 2-оос доошгүй сонингоор мэдээллэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2024 оны 04 сарын 04-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг Хавсрал № 2-оор батлсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт № 3-аар баталсугай. Хавсралт № 3-т заасан бичиг баримттай ажлын

өдрүүдэд $09^{00}$-$17^{00}$ цагийн хооронд Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Пиэрл Тауэр барилга, B корпус, 9 давхар 1 тоот оффист ирж танилцах боломжтойг дурьдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг Хавсралт № 4-ийн дагуу батлалсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2024 оны 04 сарын 24-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон, хурал зохион байгуулах комиссын даргаар Ш.Амар-отгон, гишүүнээр Н.Батнайрамдал, О.Ганчимэг Тооллогын комиссын даргаар Ө.Энхтайван, гишүүдээр Л.Даваагэрэл, Г.Бадамдорж нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ДӨЛГӨӨНТАМИР

**“Хай Би Ойл” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан**

- Нэр: “Хай Би Ойл” ХК
- Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ товчооны зам 59 тоот
- Утас: 88119740, 99904034
- Улсын бүртгэлийн дугаар: 9010001063
- Регистрын дугаар: 2615134
- Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах тусгай зөвшөөрлийнбүртгэлийн дугаар: 000009
- Үйл ажиллагааны чиглэл: Техникийн хаягдал тос дахин боловсруулах
- Үнэт цаасны тоо ширхэг: 52,118,954 ширхэг

***<u>Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:</u>***

Өмнөх оны түүхий эд болох хаягдал тосны үлдэгдэл 115,699 литр, Мазут буюу боловсруулсан тосны үлдэгдэл 164,259 литр байсан ба 2023 он гарснаас хойш тайлант хугацаанд цуглуулсан хаягдал тос 1,366,517 литр байна. Нийт 1,267,300 тонн мазут боловсруулан аж ахуйн нэгжид мазутыг борлуулсан байна. Дээрх тоон үзүүлэлтүүдийн задаргааг харуулбал:

***Түүхий эд материал:***

Хүснэгт 1. Цуглуулсан техникийн хаягдал тос болон боловсруулалтанд орсон тос

| Түүхий эд | Нэгж | 2022 оны үлдэгдэл тос | 2023 онд цуглуулсан тос | Боловсруулалтанд орсон тосны хэмжээ |
|---|---|---|---|---|
| Техникийн хаягдал тос | литр | 115,699 | 1,366,517 | 1,267,500 |

Хүснэгт 2. Техникийн хаягдал тос цуглуулсан гэрээт газрууд

| | Харилцагч компани | Литр |
|---|---|---|
| 1 | Бор-Өндөр УБҮ | 24,707 |
| 2 | Делта авт сервис ХХК | 3,400 |
| 3 | Таванбогд ХХК | 57,900 |
| 4 | Петронано ХХК | 22,800 |
| 5 | Таванбогд моторс ХХК | 26,800 |
| 6 | Оюутолгой ХХК | 775,800 |
| 7 | Тавантолгойн түлш ХХК | 1,940 |
| 8 | Грийн Го Ми ХХК | 3,000 |
| 9 | Моннис моторс ХХК | 6,000 |
| 10 | Хэра экуйпмэнт ХХК | 25,800 |
| 11 | Уулс ноён ХХК | 11,100 |
| 12 | Wolf center ХХК | 7,100 |
| 13 | Riko trans ХХК | 4,900 |
| 14 | Хьюндай моторс монгол ХХК | 4,700 |
| 15 | Шунхлай ХХК | 3,000 |
| 16 | Ач буян ХХК | 2,400 |
| 17 | Мак засварын төв | 1,300 |
| 18 | Жэйд ХХК | 18,400 |
| 19 | Түвшин саруул ХХК | 2,900 |
| 20 | Хүслэн сүбээдэй ХХК | 10,600 |
| 21 | Автосервис комплекс ХХК | 4,500 |
| 22 | Мөнхийн төгс мичид ХХК | 6,600 |
| 23 | Онно трейд ХХК | 7,200 |
| 24 | Бэрлэг майнинг ХХК | 1,200 |
| 25 | Аглаг хангайн уулс ХХК | 4,000 |

| | | |
|---|---|---|
| 26 | Шагдаржав | 6,450 |
| 27 | Паблик сервис ХХК | 72,000 |
| 28 | Батбродерс майнинг ХХК | 1,800 |
| 29 | Цагдаагийн авто бааз | 1,600 |
| 30 | Тагнуулын Ерөнхий газар | 800 |
| 31 | Коронус авто сервис ХХК | 1,400 |
| 32 | Батхүлэг ХХК | 5,800 |
| 33 | Топ моторс ХХК | 4,100 |
| 34 | Барловорлд майнинг ХХК | 32,000 |
| 35 | Эрдгео ХХК | 1,000 |
| 36 | Петротрак ХХК | 3,500 |
| 37 | Иргэний нисэхийн үндэсний төв | 2,000 |
| 38 | Б. Цолмон | 15,000 |
| 39 | Тод ундарга ХХК | 9,500 |
| 40 | Баян айраг ХХК | 56,450 |
| 41 | Элемент ХХК | 7,600 |
| 42 | Шарын гол ХК | 83,200 |
| 43 | Автоланд ХХК | 4,900 |
| 44 | МСМ ХХК | 18,000 |
| 45 | Монрок ХХК | 4,000 |
| | **Нийт** | **1,366,517** |

## ***Гэрээ хэлиэлүүд болон томоохон худалдан авагчид:***

***2023 онд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:***

| № | Гэрээ байгуулсан компани | Гэрээний агуулга | Эхлэх | Дуусах | Гэрээний үнэ |
|---|---|---|---|---|---|
| **Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ** | | | | | |
| 1 | СХД-ийн Татвар,Тохижолт цэвэрлэгээ үйлчилгээний төв | ХХҮХураамж, тээвэрлэх гэрээ | 2023/01/01 | 2023/12/31 | Улиралд 150,000 |
| 2 | Өмгөөлөгч Ө.Энхтайван | Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ | 2023/04/01 | 2023/11/01 | 8 сарын хөлс 6,000,000 |
| 3 | Г.Бадамдорж | Ажил гүйцэтгэх гэрээ / Вэб хаяг хийх/ | 2022/05/01 | 6 сард багтаан хийж гүйцэтгэнэ | Ажлын хөлс 2,500,000 |
| 4 | “Цээз ориглуун”ХХК | Хэрэглээнээс гарсан шингэн хаягдал зөөвөрлөх гэрээ | 2022/06/17 | 2023/06/17 | 1 удаагын 80,000 |

| | | | |
|---|---|---|---|
| **Мазутны гэрээ байгуулсан компаниуд** | | | |
| 1 | “Наранбулаг Хан” ХХК | Мазут худалдах гэрээ | 2023 он |
| 2 | “Тэгшт Плант” ХХК | Мазут худалдах гэрээ | 2023 он |
| 3 | “Эко Асфальт” ХХК | Мазут худалдах гэрээ | 2023 он |
| 4 | “ААШТО” ХХК | Мазут худалдах гэрээ | 2023 он |

**Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ**

| № | Гэрээ хийсэн компаниуд | Гэрээний агуулга | Эхлэх | Дуусах | Хүргэх / Авах |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Сүндэр ложистик”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/02/06 | 2024/01/06 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 2 | “Таван толгой түлш”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/01/10 | 2024/01/10 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 3 | “Грийн Го Ми”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/01 | 2024/04/01 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 4 | “Паблик сервис”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/01 | 2023/11/01 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 5 | “Бэрлэг майнинг” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/24 | 2024/04/24 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 6 | “Таванбогд”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/17 | 2024/04/17 | Газар дээрээс нь очиж авах |
| 7 | “Хэт моторс”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/08 | 2024/04/08 | Газар дээрээс нь очиж авах |
| 8 | “Шарын гол”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/08 | 2024/04/08 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 9 | “Ханбогд Вейст Менежмент центр”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/02/01 | 2024/02/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 10 | “Таванбогд моторс”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/25 | 2024/04/25 | Газар дээрээс нь очиж авах |
| 11 | “Жэйд”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/05/19 | 2024/05/19 | Газар дээрээс нь очиж авах |
| 12 | “Автосервис комплекс” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/05/31 | 2024/05/31 | Газар дээрээс нь очиж авах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | “Бан Идеал” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/05/29 | 2024/05/29 | Газар дээрээс нь очиж авах |
| 14 | “Мөнхийн төгс мичид”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/05 | 2024/04/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 15 | “Хүслэн сүбээдэй”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/02 | 2024/04/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 16 | “МСМ” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/04/01 | 2024/04/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 17 | “Онно трейд” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/12 | 2024/04/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 18 | “Эм Ти Юу”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/07 | 2024/04/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 19 | “Жавхлант Алдар Мөнх” ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/01 | 2024/06/01 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 20 | “НБИК”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/30 | 2024/04/01 | Үйлдвэрт хүргэж өгөх |
| 21 | “Тэгшт Плант”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/30 | 2024/06/30 | Газар дээрээс нь очиж авах |
| 22 | “Боржин зам”ХХК | Техникийн хаягдал тос авах | 2023/06/30 | 2024/06/30 | Үйлдвэрт хүргэж өгөх |

***2023 онд хийгдсэн ажилууд:***

1. Боловсруулсан бүтээгдэхүүн болон М-100 маркын мазутыг Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лабортори “Амбер” ХХК-иар улиралд 2 удаа шинжлүүлэн баталгаажуулсан.


АМБЕР ХХК
Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний MNS ISO/IEC17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори
AMBER LLC

СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №02101/23

ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дээж ирүүлсэн байгууллагын нэр: Хай Би Ойл ХК
Дээжийг авсан газар: Улаанбаатар, Монгол
Дээжийн төрөл: Мазут
Дээж авсан объект: Сав
Дээжийн хэмжээ: 1.2 литр
Дээж авсан огноо:2023.04.27 | Хүлээн авсан огноо:2023.04.27 | Шинжилсэн огноо:2023.04.28

СОРИЛТЫН ҮР ДҮН

| | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Сорилт гүйцэтгэсэн стандарт | Норм MNS 3828:2008 /M100/ | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 15°С дахь хувийн жин | г/см³ | MNS 0481 | - | 0.8804 |
| 2 | Кинематик зуурамтгай 50 °С-т | мм²/с | MNS 0480 | - | 51.735 |
| | 100 °С-т | | | 50.0 ихгүй | 8.133 |
| 3 | Механик хольцын хэмжээ | % | MNS 0322 | 1.5 ихгүй | байхгүй |
| 4 | Усны хэмжээ | % | MNS 0332 | 1.0 ихгүй | 1.931 |
| 5 | Задгай тигельд асч үүсгэх хэм | °С | MNS 0328 | 110.0 багагүй | 133.0 дээш |
| 6 | Царцах хэм | °С | MNS 3192 | /25.0/ ихгүй | /-39.0/ |
| 7 | Өнгө | - | MNS ISO 2049 | - | хар |

Шинжилгээ хийсэн химич Б.Мандахнаран
Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч Г.Энхтунгалаг

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251
000128863


АМБЕР ХХК
Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний MNS ISO/IEC17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори
AMBER LLC

СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №03104/23

ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дээж ирүүлсэн байгууллагын нэр: Хай Би Ойл ХК
Дээжийг авсан газар: Улаанбаатар, Монгол
Дээжийн төрөл: Мазут
Дээж авсан объект: Сав
Дээжийн хэмжээ: 0.9 литр
Дээж авсан огноо:2023.06.21 | Хүлээн авсан огноо:2023.06.22 | Шинжилсэн огноо:2023.06.22

СОРИЛТЫН ҮР ДҮН

| | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Сорилт гүйцэтгэсэн стандарт | Норм MNS 3828:2008 /M100/ | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 15°С дахь хувийн жин | г/см³ | MNS 0481 | - | 0.8804 |
| 2 | Кинематик зуурамтгай 50 °С-т | мм²/с | MNS 0480 | - | 97.83 |
| | 100 °С-т | | | 50.0 ихгүй | 12.45 |
| 3 | Механик хольцын хэмжээ | % | MNS 0322 | 1.5 ихгүй | байхгүй |
| 4 | Усны хэмжээ | % | MNS 0332 | 1.0 ихгүй | байхгүй |
| 5 | Задгай тигельд асч үүсгэх хэм | °С | MNS 0328 | 110.0 багагүй | - |
| 6 | Царцах хэм | °С | MNS 3192 | /25.0/ ихгүй | /-32.0/ |
| 7 | Өнгө | - | MNS ISO 2049 | - | хар |

Шинжилгээ хийсэн химич Б.Мандахнаран
Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч Б.Алъяа

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251

4. Нийслэл хот дотроо үйл ажиллагаа явуулдаг авто засварын газруудаас “Техникийн ашигласан хаягдал тос” тээвэрлэдэг зориулалтын автомашинд хот дотор явах ЕС зөвшөөрлийн сунгалтыг хийлгэж хагас жилээр түр зөвшөөрлөө авсан.




*Зураг 4. Тээврийн хэрэгслийн ЕС зөвшөөрөл*

5. Ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернүүдэд (Kia Rhino) ээлжит урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ЕС зөвшөөрөл, хот дотор явах түр зөвшөөрөл (бүтэн жилээр буюу 2022.12.31-г дуустал), тээврийн хэрэгслийн татвар, улсын үзлэг, оношилгоо, даатгалд зэрэгт хамруулсан.




*Зураг 5. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ*

6. Хаягдал тос буулгах цэгийн хөрсийн хамгаалах үүднээс бохирдсон хөрсийг хусаж цэвэрлэх, саармагжуулалт хийх, хөрсийг ажил эхлүүлсэн болно.






*Зураг 6. Хөрс хусаж цэвэрлэх*

7. Хаягдал тос буулгах цэгийн хөрсийн хамгаалах үүднээс бохирдсон хөрсийг бетондож, хөрсний бохирдсон хэсгийн хорыг саармагжуулах ажил хийгдсэн.



*Зураг 7. Бетондсон хэсэг*





*Зураг 8. Агуулах савны хажуу талбай*

8. Техникийн хаягдал тос дахин боловсруулахад өдөрт 2 тонн усыг хөргөлтийн журмаар ашигладаг ба үйлдвэрийн хөргөлтийн системийг өргөжүүлэн үйлдвэрийн гадна талд нэмж байрлуулан байнгын сэлгэн хөргөдөг болгож өөрчлөв.





*Зураг 9. Хөргөлтийн төхөөрөмж*

9. Үйлдвэрийн хашаан дотор хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу улиас, хайлаас, гацуур мод тарьж , зүлэгжүүлэх, ногоон байгууламжтай болгож байна.







*Зураг 10. Ногоон байгууламж*

10. Аянга зайлуулагч болон тоног төхөөрөмжийн газардуулга эсэргүүцлийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулалт хийлгэсэн.







*Зураг 10. Аянга зайлуулагч*

11.  8 ширхэг түүхий эд болон, эцсийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулахаа үл нэвчих грунт, будгаар будах, бохирдуулахаас сэргийлэх



*Зураг 11. Агуулах савны будаг*

## 11.2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Борлуулалт: 2023 оны жилийн эцэсээр 864,889,597.73 төгрөгийн борлуулалтын орлого, 149,367,745.75 төгрөгийн өртөгтэй.
Цэвэр ашиг нь: 51,040,035.42₮

Авлага: 234,126,198.0 төгрөг
Өглөг: 149,687,026.0 төгрөг байна.

Зардалууд:

| | | |
|---|---|---|
| 1. | Цалингийн зардалд | 88,826,828.46₮ |
| 2. | НДШ-д | 28,512,990.05₮ |
| 3. | Ашиглалт болон урсгал засвар үйлчилгээнд | 31,146,317.98₮ |
| 4. | Албан татварт | 47,499,211.10₮ |
| 5. | Түлш шатахуун тээвэрт | 145,813,283.22₮ |
| 6. | Элэгдэл, хорогдлын зардал | 102,095,290.17₮ |
| 7. | Шуудан холбоо,бичиг хэрэг, даатгалд | 3,540,009.52₮ |
| 8. | Засвар үйлчилгээнд | 34,799,169.45₮ |
| 9. | Түрээс | 2,100,000₮ |
| 10. | Харуул хамгаалалт | 22,400,000₮ |
| 11. | Бусад зардалд | 127,716,809.94₮ -ийн зардлууд тус тус гарсан байна. |

**Нийт зардал нь: 634,449,909.89₮**

## 12. 2023.04.24 ”Хай Би Ойл” ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:

2023 оны 04 сарын 24-ны өдрийн Баасан гаригийн 11:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18235 товчооны зам гудамж, 59 тоотод байрлах өөрийн байранд зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

а.Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

b. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

c. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл.

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудсанд тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Компани нь нийт 52’118’954 ширхэг хувьцаатай ба 386 хувьцаа эзэмшигчидтэй байна.

Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Нийт хувьцааны Тоо ширхэг | Хувь |
|---|---|---|---|
| 1 | “Төгөлдөр мегаминкс” ХХК | 8,256,727 15. | 84% |
| 2 | “Кибер цирк” ХХК | 16,609,841 | 31,87% |
| 3 | “Монгол алтан минт” ХХК | 4,167,934 | 8.00% |
| 4 | “Нью альфа” ХХК | 17’327’908 | 33.25% |
| | | Дүн | 88.95% |

/ ҮЦТХТ-өөс 2023.04.04-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

**Удирдлагын талаархи мэдээлэл:**

2023.04.24-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Пүрэвбаатар, Ш.Амар-Отгон, Т.Батгэрэл, С.Одгэрэл, Р.Оюунбат, Б.Дөлгөөнтамир нар, хараат бус гишүүдээр А.Харцага, Т.Тамир, Н.Гүнжидмаа нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Дөлгөөнтамир, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

**ТУЗ-ийн хурлын талаар:**

Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 7 удаа санал асуулгаар хуралдсан байна. Үүнд:

1. 2023 оны 02 сарын 06-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж “Эвиденсе аудит”ХХК-аар 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх шийдвэрийг гаргасан.
2. 2023 оны 02 сарын 06-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж “Хай Би Ойл” ХК-иыйн хувьцаа эзэмшигчдэд 2022 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хувиарлахгүй болохыг тогтоож шийдвэрлэсэн.
3. 2022 оны 03 сарын 15-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2023 оны 04 сарын 24-ны Даваа гаргигийн 11 цагт хуралдуулхаар шийдвэрлэсэн.
4. 2023 оны 05 сарын 02-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2023 оны 04 сарын 24-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ын гишүүдээс ТУЗ-ын дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж шийдвэрлэсэн болно. Мөн өдөр Хай Би Ойл ХК-ийн ахлах оператор П.Баатархүүд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож шийдвэрлэсэн.

## “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

### Ердийн гишүүнд нэр дэвшигчид

1. **Сүрэнжавын Одгэрэл** 1981 онд Архангай аймаг Цэцэрлэг суманд төрсөн. “Женко” дээд сургуулийг 2002 онд Бизнес удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. 2002 онд Нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн, 2007 онд Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч болсон. 2002-2004 онд “Ситишоп” ХХК-д нягтлан бодогч, 2004-2007 онд “Алтанжирэм” ХХК-д Нягтлан бодогч, 2007-2009 онд “Цайрт минерал” ХХК-д Татварын ня-бо, 2009-2010 онд “MW holding” ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, 2010 оноос одоог хүртэл “Професи Пауэр Женерэйшн” ХХК-д Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна.

2. **Раднаагын Оюунбат-** 1973 онд Улаанбаатар хотод төрсөн. ШУТИС-ийг 1998 онд Химийн инженер технологичоор бакалавр, 2010 онд ШУТИС-ийн Химийн инженер магистр, 2012 оноос ШУТИС-ийн Химийн инженерийн докторантаар тус тус суралцсан. 2017 оноос ШУТИС Монгол улсын зөвлөх инженер. ШУТИС-ын БИС-д 1 жил Сургалтын мастер, Алтандорнот Монгол ХХК-д 2 жил Төслийн инженер, ММНС ХХК, Эм Эм И Жи ХХК-д 5 жил Төслийн инженер, ерөнхий инженер, химийн инженер, Гүйцэтгэх захиралаар, Монгол газар ХХК-д 11 жил Химийн инженер, лабораторийн эрхлэгч, ХБҮйлдвэрийн ерөнхий технологич, Үйлдвэрийн даргаар тус тус ажилсан.

3. **Баярсайханы Пүрэвбаатар-** 1986 онд Архангай аймгийн Тариат суманл төрсөн. 2010 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг Бизнесийн удирдлагын баклавар зэрэгтэй төгссөн. “Фронтиер Секюритис” ХХК-д корпорацийн санхүүчээр, “Говь Караван” ХХК-д Бизнес Хөгжлийн Албаны захиралаар, “Би Эй Пи” ХХК-ийн гүйцэтгэх захиралаар “Хай Би Ойл” ХК-ийн санхүү эрхэлсэн захирлаар тус тус ажиллаж байсан. Одоо “Хэрлэн онон туул” ББСБ-ын Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

4. **Болдын Дөлгөөнтамир-** 1985 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн. 2007 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжилээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Банк санхүүгийн мэргэжилээр мэргэшсэн. Зоос банк болон Хас банкинд 2007-2017 онуудад Эдийн засагч, бизнесийн зээлийн мэргэжилтэнгээр ажиллаж байсан. Одоо “Төгөлдөр мегаминкс” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

5. **Шаравын Амар-отгон-** 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. 1999 онд “Ирээдүй” дээд сургуулийг Япон хэлний багш орчуулагч мэргэжилээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 2001 онд Японд “Сэншюү”дээд сургуульд сурсан. 2009-2012 онд Япон-Монголын Найрамдлын Нийгэмлэгт орчуулагчаар ажилласан. 2012-2018 онд Японд ажиллаж, амьдарч байгаад 2019 оноос “Хай Би Ойл”ХК-ийн гүйцэтгэх захирлаар 6 дах жилдээ ажиллаж байна.

6. **Б.Батбаатар** – АНУ-ын Жеймс Медисоны их сургуулийг төгссөн. Жорж Вашингтоны их сургуульд бизнесийн удирдлагын мастерийн зэрэг хамгаалсан. MICC хөрөнгө оруулалтын банкны дэд ерөнхийлөгч, Мянганы сорилын санд эдийн засагч, Си Си Пи хөрөнгө оруулалтын банкинд Санхүү эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байсан. Одоо Шарын гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

### Хараат бус гишүүнд нэр дэвшигчид

1. **Тулгийн Батгэрэл-** 1977 онд Увс аймгийн Өндөрхангай суманд төрсөн. 1999 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг Нягтлан бодогч, Эдийн засагч мэргэжилээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 1999-2006 онд “Чингис шар айраг” ХХК-д ахлах нягтлан бодогчоор ажиллаж байсан. 2006 оноос хойш өнөөдрийг хүртэл “Ньюком” ХХК-д Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна.

2. **Тэрбишийн Тамир** – 1980-1990 онуудад 10 жилийн 1-р сургууль, 1992-1997 онуудад ШУТИС-ийг Барилгын инженерийн сургууль Архтектурч мэргэжилээр, Барилга Архитектур Корпорацид эрдэм шинжилгээний ажилтанаар 4 жил, “Амейзэ” ХХК-д Гүйцэтгэх захирлаар 16 жилдээ ажиллаж байна.

3. **Нямжаргалын Гүнжидмаа**–1989 онд Улаанбаатар хотод төрсөн. 2011 онд Энэтхэгийн Банголорын Их сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжилээр бакалавр зэрэгтэй, 2019 онд Их засаг Их сургуулийг Эрх зүйч мэргэжилээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. 2012-2014 онд “Нарантрейд” ХХК-д, 2014-2019 онуудад “Могул пауэр” ХХК, “Нагай” ХХК-д тус тус ажиллаж байсан.

**“ХАЙ БИ ОЙЛ” ХК – ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 02 сарын 05 өдөр Дугаар 03 Улаанбаатар

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт болон “Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Хай Би Ойл” ХК-ийн 2023 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Ш.Амар-отгон/-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **Б.ДӨЛГӨӨНТАМИР**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 15-ний
өдрийн 03 тогтоолын Хавсралт №4

**“ХАЙ БИ ОЙЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .........................нэр...........................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо .................. Кумулятив саналын тоо........................
Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .......................................
Брокерийн овог .................................... нэр ..................................

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Пиэрл Тауэр барилга, В корпус, 9 давхар 1 тоотод болно.

| *д/д* | | *Хэлэлцэх асуудлын нэр* | *Хурлаас гарах шийдвэрийн төсөл* | *Зөвшөөрсөн* | *Татгалзсан* | *Түдгэлзсэн* | *Татгалзсан тохиолдолд таны өгөх санал* |
|---|---|---|---|---|---|---|---|
| *1* | | *Компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.* | *Тогтоол ТУЗ-ийн дүгнэлтийг батлах* | | | | |
| *2* | | *Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох* | | *Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/* | | | |
| | *1* | Ш.Амар-Отгон | | | | | |
| | *2* | Б.Дөлгөөнтамир | | | | | |
| | *3* | Б.Пүрэвбаатар | | | | | |
| | *4* | Б.Батбаатар | | | | | |
| | *5* | С.Одгэрэл | | | | | |
| | *6* | Р.Оюунбат | | | | | |
| | | | | | | | |
| | | *Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох* | | *Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/* | | | |
| | *1* | Н.Гүнжидмаа | | | | | |
| | *2* | Т.Тамир | | | | | |
| | *3* | Т.Батгэрэл | | | | | |
| | | | | | | | |

Брокер ............................................. Гарын үсэг
/ тэмдэг /
Хувьцаа эзэмшигч ............................. Гарын үсэг

2024 оны ... сарын ... өдөр

**ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана**. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.**Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын

эрхтэй /100*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх талаарх мэдээллийг 88035811 утсаар лавлаж болно.
4. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан ......................................................................................................................................................................................................